

## ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ОФИЦЕР БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АРГА ЗАМ

Ж.ЭНХТУЯА

ДХИС-ийн АШБС-ийн Гамшиг  
судлалын магистрант ахлах дэслэгч

### Товч агуулга

Манай оронд ган, зуд, цасан болон шороон шуурга, объектын болон ой хээрийн түймэр, цөлжилт, хэт халалт, хүйтрэл зэрэг байгалийн гамшгаас гадна хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, хортон шавьжны тархалт, үйлдвэр, тээврийн хэрэгслийн осол, цацраг идэвхт хордолт, химийн хорт бодисын алдагдалт зэргээс хүний амь эрсдэх, улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжил, хүрээлэн буй орчинд ихээхэн хохирол учирсаар байна. Түүгээр ч үл барам зарим урьд өмнө гарч байгаагүй шинэ төрлийн өвчин үүсэн бий болж, гамшиг, ослын аюул занал шинэ төрөл, хэлбэрээр үүсэх нь бий боллоо. Энэ байдлын улмаас гамшгийн аюулын хэмжээ, тоо давтамж өсч, чиг хандлага өөрчлөгдөж байгаатай уялдан Онцгой байдлын байгууллагын гүйцэтгэх, үйл ажиллагааг өргөжүүлэх бодит шаардлага бий болж байна.

Аливаа байгууллагын хувьд ч хүний нөөц нь хамгийн үнэ цэнэтэй хязгааргүй өсөн нэмэгддэг шавхагдашгүй нөөц тул хүн тухайн байгууллагын үнэт баялаг. Байгууллагын амжилт тухайн байгууллагад ажиллаж байгаа хүмүүсийн мэдлэг, авьяас чадвар, тэдгээрийн хөгжил, тогтвор суурьшлаас хамаарах төдийгүй тэдгээрийг оновчтой төлөвлөх, зохион байгуулах үйл ажиллагаанаас шалтгаалж байдаг. Байгууллагын ажилчдыг сургах, тэднийг давтан мэргэшүүлж, ажлын дадлага ур чадварыг нэмэгдүүлэх нь ямар ч байгууллагын эрхэм зорилгын бүрэлдэхүүн хэсэг, зайлшгүй хэрэгцээ бөгөөд үүнийг орчин үеийн байгууллагуудын хөгжих амжилтын нэг үндэс гэж үздэг байна. Онцгой байдлын байгууллагад ажиллаж буй хүмүүсийн ажлын гүйцэтгэлээс байгууллагын ажлын эцсийн үр дүн хамаарна.

**Түлхүүр үгс:** Гамшгаас хамгаалалт, зохион байгуулалт, засаг захиргаа, хүний нөөц, бие бүрэлдэхүүн, бие бялдар, хамт олон

### Удиртгал

Өндөр хурдацтай өөрчлөгдөж байгаа шинжлэх ухаан, техник, технологийн хөгжил дэвшил, өөрчлөлт зэрэгт зохицон ажиллахын тулд байгууллага ажиллагсдынхаа мэдлэг, чадвар, чадамжийг байнга тасралтгүй дээшлүүлж байхыг шаардаж байна. Тиймээс байгууллагын шаардлагад нийцсэн боловсон хүчинтэй байх, тэрхүү боловсон хүчнийхээ мэдлэг мэргэжил, ур чадварыг хэрхэн нэмэгдүүлэх талаар системтэй үйл ажиллагаа явуулах зайлшгүй шаардлага бий болж байгаа билээ.

Онцгой байдлын байгууллагын офицерын бүрэлдэхүүний салбарт явагдаж буй сургалт, бэлтгэл, түүний тогтолцоо, сургалтын агуулга, арга зүй боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тулгарч байна. Иймд онцгой байдлын байгууллагын офицерын бүрэлдэхүүний сургалтын арга зүйг шинжлэн судлах хэрэгцээ шаардлагын үүднээс энэхүү сэдвийг сонгосон юм.

## Онолын хэсэг

Энэ бүлэгт онцгой байдлын албаны офицерын бүрэлдэхүүний сургалтыг сайжруулах боломжийн холбоотой хийгдсэн судлаачдын зарим бүтээл, судалгааны ажлуудыг тоймлон авч үзнэ. Онцгой байдлын албаны офицер бүрэлдэхүүний сургалтын сэдвээр тусгайлан судалсан бүтээл алга байна. Судалгааны ажлын сэдэвт тусгагдсан онцгой байдлын албаны үндсэн нэр томьёо, ойлголт ухагдахуунуудыг дараах байдлаар тодорхойлж байна.

**Онцгой байдал** гэж байгалийн аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол болон нийгмийн шалтгаантай аюулын нөлөөгөөр хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд хохирол учирсан буюу учруулахуйц нөхцөл байдал үүсэхийг хэлнэ<sup>1</sup>.

**Онцгой нөхцөл байдал** гэж тодорхой нутаг дэвсгэрт осол, байгалийн аюулт үзэгдэл, сүйрэл, байгалийн бусад гамшгийн улмаас хүний амь нас үрэгдэх, хүмүүсийн эрүүл мэнд буюу хүрээлэн буй байгаль орчинд гэм хор учруулах, материалын үлэмж хохирол бий болох, хүмүүсийн амьдралын хэвийн үйл ажиллагаа алдагдахаар нөхцөл байдал үүсэхийг хэлнэ (С.Нарангэрэл, 2015).

**Онцгой байдлын удирдлага** гэж онцгой байдлын бүх асуудлаар, тухайлбал, бэлэн байдал, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр нөөц, үүрэг хариуцлагыг зохион байгуулах, удирдахыг хэлнэ Онцгой байдлын удирдлагад онцгой байдлын улмаас үүссэн бүхий л хэрэгцээ, шаардлагыг зохицуулах олон талт үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, сайн дурын байгууллагуудыг оролцуулахаар бий болгосон төлөвлөгөө, бүтэц, зохицуулалтууд багтана.

**Онцгой байдлын байгууллага, түүний тогтолцоог** “Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн” (Хууль, Гамшгаас хамгаалах тухай, 2017) хэмээн заасан<sup>2</sup>.

**Гамшгаас хамгаалах сургалт** гэж Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд улсын алба, засаг захиргаа, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг сургаж, дадлагажуулах үйл ажиллагааг (Монгол Улсын стандарт, MNS 6010:2009) авч үзжээ. Сургалт гэдэг ухагдахууны талаар эрдэмтэн судлаачдын олон тодорхойлолт байдаг. Тэдгээрийг тоймлон нэгтгэн авч үзвэл:

- Сургалт бол тодорхой тогтолцоо бүхий мэдлэг, чадвар, дадал төлөвшүүлж, боловсрол олгох, дамжуулах үйл ажиллагаа, төлөвлөгдсөн үйл явц, арга хэрэгсэл, суралцах, сурахуйн нэгдэл юм.<sup>3</sup>

- “Сургалт бол гамшгаас урьдчилан сэргийлэх иргэн бүрт хүрч ажиллах түлхүүр мөн” гэж ШУ-ны доктор, профессор О.Үржин тэмдэглэн хэлсэн байна. (О.Үржин, 2001)

## Судалгааны хэсэг

Онцгой байдлын албаны офицерын бүрэлдэхүүний сургалтын өнөөгийн байдалд шинжилгээ хийж, сайжруулах арга замыг судалж тодорхойлоход оршино. Онцгой байдлын офицерын бүрэлдэхүүний сургалтын сайжруулах арга зам” сэдэвт судалгааны ажлын хүрээнд: Гадаадын болон өөрийн орны эрдэмтэн судлаачдын эрхлэн гаргасан ном, товхимол, эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, судалгааны

ажилдаа судалж оруулна. Судалгааны өгөгдөл, мэдээллийг цуглуулахдаа нийгмийн шинжлэх ухаанд түгээмэл хэрэглэгддэг аргуудыг ашиглана. Онцгой байдлын албанд олон жил ажилласан удирдах ажилтнууд болон хүний нөөцийн чиглэлээр мэргэшсэн алба хаагчдын саналыг авна. Гадаадын зарим улс орнуудын туршлагад тулгуурлан Онцгой байдлын албаны офицерын бүрэлдэхүүний өнөөгийн байдалд шинжилгээг хийж, ололт дэвшилттэй талыг харж офицерын бүрэлдэхүүний сургалтад нэвтрүүлэх боломжийг судлан, сургалтыг сайжруулахад шинэлэг шийдэл, санал боловсруулж гаргах нь судалгааны ажлын шинэлэг тал болно.

### Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг зохион байгуулах ерөнхий журам

Онцгой байдлын албаны сургалтын бодлого нь Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагад алба хаах журам, Хүний нөөцийн бодлогод үндэслэн онцгой байдлын алба хаагчдыг ажлын байранд сургаж бэлтгэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд баримтлах үндсэн баримт бичиг мөн. Энэхүү журам нь Онцгой байдлын албаны бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг зохион байгуулахад чиглэгдэнэ.

Онцгой байдлын алба хаагчдад мэргэжил эзэмшүүлэх, мэргэшүүлэх, тэднийг хөгжүүлэх сургалтыг зохион байгуулах, сургалт бэлтгэлийн үр дүнг тооцох, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмаар зохицуулна

**Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэл** гэж Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагад хуулиар хүлээсэн “Гамшгийн аюулаас хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, эдгээр үйл ажиллагаанд хүн амыг сургаж бэлтгэх” үндсэн үүргийг биелүүлэхэд шаардлагатай мэдлэг, дадлага, чадвар, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлийг бие бүрэлдэхүүнд эзэмшүүлэх, төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги, байгууллагын үүрэг гүйцэтгэх бэлтгэл, бэлэн байдал, жигдрэлтийг хангахад чиглэгдсэн зохион байгуулалттай, тодорхой зорилго, чиглэл бүхий цогц үйл ажиллагааг хэлнэ.

**Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэл нь** /цаашид сургалт бэлтгэл гэх/ төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги, байгууллагын албаны бэлтгэл, гамшгийн нөхцөлд гүйцэтгэх бэлэн байдлын бүрэлдэхүүн хэсэг мөн.

### Сургалт бэлтгэлийг дараах зарчимд тулгуурлан явуулна. Үүнд:

- Шинжлэх ухааны үндэстэй байх;
- Тодорхой зорилго чиглэлтэй байх;
- Гамшгаас хамгаалах үндсэн үүргийг биелүүлэхэд шаардлагатай бүхэнд сургах;
- Үүсч болзошгүй гамшгийн цагийн байдалд ойртуулсан байх;
- Суралцагчдын ухамсартай, санаачилгатай, бүтээлч, бие даасан байдалд тулгуурлах;
- Дэс дараалалтай, иж бүрэн (цогцолбор), хөнгөнөөс хүнд рүү шилжиж байх;
- Идэвхтэй, тасралтгүй, оновчтой байх;
- Нийт албан хаагчдад хүртээмжтэй байх

- Ёс зүй, хүмүүжлийн нөлөөтэй байх;
- Байнга шинэчлэгдэж боловсрогдож байх зарчмыг баримталдаг.

### Сургалт бэлтгэлийн тогтолцоо

Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийн тогтолцоо нь албан ба албан бус сургалтын нэгдэл байх бөгөөд алба хаагчдад мэргэжлийн боловсрол олгох, мэргэшүүлэх болон давтан сургах, хөгжүүлэх гэсэн үндсэн төрлүүдээс бүрдэнэ. Албаны сургалт бэлтгэлийг бүтэц, хамрах хүрээ, зориулалт, үе шатаар нь ангилна.

**Бүтцээр нь:** хүн нэг бүрийн, анги салбарын, газар хэлтсийн, штабын бэлтгэл; **Хамрах хүрээгээр нь:** дагнасан (газар, хэлтэс, анги, байгууллагын), хамтарсан, нэгдсэн;

**Зориулалтаар нь:** албаны бэлтгэл, гамшгийн нөхцөл байдлын үед үүрэг гүйцэтгэх бэлтгэл (олон талт үүргийн бэлтгэл);

**Үе шатаар нь:** сургуулийн жилийн эхний хагас-I үе, сүүлийн хагас -II үе; **Хүн нэг бүрийн бэлтгэлийг бүтцээр нь:** офицерын, ахлагчийн; Сургалтын хэлбэрээр нь: онолын, дадлагын, бие даалтын гэж ангилна.

**Штабын бэлтгэлээр:** Онцгой байдлын удирдах албан тушаалтны үйл ажиллагааг штабын албаны болон гамшгийн нөхцөл байдлын үед үүрэг гүйцэтгэхэд бэлтгэх, сургалт бэлтгэлийн түвшинг дээшлүүлэх, гамшгийн нөхцөл байдалд нийцсэн хамгийн оновчтой шийдвэрийг богино хугацаанд боловсруулж, бүтээлчээр хэрэгжүүлэх чадварыг эзэмшүүлнэ.

**Штабын бэлтгэлийг масштабээр нь:** тактикийн, оперативын;

**Хамрах хүрээгээр нь:** хэсэгчилсэн, хамтарсан буюу нэгдсэн; <sup>4</sup>

**Сургалтын хэлбэрээр нь:** штабын дадлага, команд штабын сургууль, иж бүрэн сургууль гэж ангилна.

**Офицер, ахлагч нарын сургалт нь:** тэдэнд албан тушаалын үүргээ гүйцэтгэхийн зэрэгцээ, томилгоот үүргийг гүйцэтгэх, бие биенээ орлон ажиллах, нэг шат дээгүүр албан тушаалын үүргийг хариуцан биелүүлэхэд шаардлагатай мэдлэг, дадлага, ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэгдэх ба албан тушаал, ажилласан жил, боловсролын түвшингээр нь ялгавартай зохион байгуулна.

**Албаны бэлтгэлээр:** “Гамшгаас хамгаалах тухай” Монгол Улсын хуулиар хүлээсэн үндсэн үүргийг гамшгийн нөхцөл байдлын ямар ч тохиолдолд амжилттай биелүүлэхэд шаардлагатай мэдлэг, дадлага, ур чадварыг эзэмшүүлж, анги, байгууллага, салбарын жигдрэлт, харилцан ажиллагааг хангана.

**Гамшгийн нөхцөл байдлын үед:** үүрэг гүйцэтгэх бэлтгэл болон олон талт үүргийн бэлтгэл нь Гамшгаас хамгаалах тухай болон Батлан хамгаалах бусад хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх үндсэн үүрэг, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагатай хамтран ажиллах бэлтгэл, бэлэн байдлыг хангахад чиглэгдэнэ.

Онцгой байдлын албаны сургуулийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 05-наас 12 дугаар сарын 05-ны өдөр хүртэлх хугацаанд үргэлжилнэ. Сургуулийн жилийн эхний хагас I үе нь 01 дүгээр сарын 15-наас 05 дугаар сарын 15-ныг хүртэл, сүүлийн хагас II үе нь 09 дүгээр сарын 05-наас 12 дугаар сарын 05-ныг хүртэлх хугацааг тус тус хамарна. Заах арга зүйн сургалтыг офицер, ахлагч сургагч багш нарт сургалтын онол, заах арга зүй, сургалт бэлтгэлийн зохион байгуулалт, сургалтыг удирдаж явуулах ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор сурган зааварлах, үзүүлэх болон нээлттэй хичээл, зааварчилга өгөх аргаар жил бүр зохион байгуулна. Удирдах бүрэлдэхүүний заах арга

зүйн бэлтгэлийг сургуулийн жилийн өмнө Удирдах ажилтны цугларалтаар Гамшгаас урьдчилан сэргийлэх газар, төв, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтэс, анги, байгууллагад заах арга зүйн бэлтгэлийг сургуулийн жилийн өмнө Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэс, тасаг, ангийн штабаас зохион явуулна.

### Сургалт бэлтгэлийн хичээл, түүний агуулга

Сургуулийн жилд офицер, ахлагчийн бүрэлдэхүүнд “Гамшгийн менежмент”, “Аюулгүй байдал, эрх зүйн үндэс”, “Эрүүл мэнд-сэтгэл зүйн бэлтгэл”, “Биеийн тамирын бэлтгэл”, “Ёс зүйн хүмүүжил”, “Цэргийн хэрэг, жагсаалын бэлтгэл”, “Гадаад хэлний бэлтгэл”, “Тусгай бэлтгэл” зэрэг хичээл явагдана.

Хичээлийг сургуулийн жилийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган, сургалтын цагийн ачааллын 40 хүртэл хувийг онолоор, 60 хүртэл хувийг дадлагаар суралцуулна.

### Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийн менежмент:

Сургалт бэлтгэлийн менежмент гэж бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийн талаар дэвшүүлсэн зорилт, тушаал, шийдвэрийн заалтуудыг биелүүлж, анги, байгууллага нь албаны болон болзошгүй гамшгийн цагийн байдлын үед үүрэг гүйцэтгэх бэлтгэл, жигдрэлтийг хангахын тулд бүх шатны удирдлага, штаб, албан тушаалтнаас сургалтын үйл явцыг төлөвлөх, зохион байгуулах, шаардагдах материал, санхүүгийн нөөцийг зохицуулах, хянах чиг үүргүүдийг хэрэгжүүлж буй удирдлагын шинжлэх ухаанч үйл ажиллагааг хэлнэ.

Монгол Улсын хууль, тогтоомж, Шадар сайдын тушаал, шийдвэрийн холбогдох хэсэг, Онцгой байдлын албаны сургалтын бодлого, энэхүү журам, сургуулийн жилийн удирдамж, сургалт бэлтгэлийг шалгаж үнэлэх заавар, сургалт бэлтгэлд хийх хяналт, шалгалтын ажлын удирдамж, төв, орон нутгийн онцгой байдлын газар, анги, байгууллагын дарга, захирагч нарын бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг зохион байгуулах тухай тушаал, сургалт бэлтгэлийн стандарт, сургалт бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөө, хичээл, сургууль, дадлагыг зохион байгуулах тухай удирдамж, заавар, журам, төлөвлөгөө, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх төлөвлөгөө зэрэг сургалт бэлтгэлийг төлөвлөх, суралцагчдад үүрэг хүргэх ба түүний биелэлтийг шалгахад зориулагдсан баримт бичгүүд хамаарна.

### Оросын холбооны улсын онцгой байдлын алба болон иргэний хамгаалалтын академийн офицеруудын зарим сургалтын талаар


Иргэний хамгаалалтын академийн үндэс суурь 1930 оноос эхтэй. Батлан хамгаалах чиглэлээр үйл ажиллагааг явуулж байсан. 1994 онд Оросын холбооны улсын онцгой байдлын асуудал эрхэлсэн яамны харьяа иргэний хамгаалалтын академи гэж нэрлэгдсэн.

Иргэний хамгаалалтын академи нь 2 институт, 6 факультет, 29 тэнхимтэй. Тус академид мастер сургалтын дөрвөн чиглэлээр, мэргэжилтний 2 чиглэл, бакалаврын сургалтын 12 чиглэлээр хоёр мянга гаруй хүн суралцдаг.

Мэргэжилтнүүдийн боловсрол, сургалтын үр нөлөө жилээс жилд нэмэгдэж байдаг Академийн шинжлэх ухаан, багш ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, нэгжүүдийн техник хэрэгслийн түвшин, мэргэжилтнүүдийн тоо, мэргэшлийн түвшин өндөр. Иргэний хамгаалалтын академийн үндсэн үйл ажиллагаа нь Оросын холбооны улсын хүн ам, нутаг дэвсгэрийг онцгой байдлын байдлын хүчин зүйлээс хамгаалах чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх явдал юм.



Иргэний хамгаалалтын академид суралцах офицеруудын нөхцөл байдлын хувьд: Оросын холбооны улсын онцгой байдлын яамны харъяа анги салбаруудын офицеруудаас жилд ойролцоогоор 20 офицер шалгаруулж тус академийн нутаг дэвсгэр дээр офицеруудын байранд 2 жилийн хугацаагаар гэр бүлтэй нь байрлуулж академийн ахлах мэргэжилтнүүд бэлтгэх факультетад сургаж бэлтгэн төгсгөдөг байна. Академид гадаадаас ирж суралцаж байгаа офицеруудын хувьд мөн академийн гадаад офицеруудын байранд 2 жилийн хугацаатай байрлаж гадаад мэргэжилтэн бэлтгэх факультетад бэлтгэж төгсгөдөг. Тус 2 жилийн хугацаанд зонхилох хичээлүүд нь: Цэргийн удирдлагын онол, хууль эрх зүйн хичээлүүд, удирдлагын өдөр тутмын үйл ажиллагааны төлөвлөлт бэлэн байдал, материал техникийн ар тал хангалт, биеийн тамирын бэлтгэл, онцгой байдлаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах улсын нэгдсэн тогтолцоог судлах, шуурхай удирдлага, онцгой комисс, байгууллагуудын удирдлагын үйл ажиллагааг системтэйгээр судалж команд штабын сургуулийг семистрийн төгсгөлд зохион байгуулдаг байна. Танхимийн сургалт нь 09:00-17:00, бие даалтын цаг 17:00-18:00 цаг хүртэл явагддаг байна. Оросын холбооны улсын хүн ам ард иргэд нийтээрээ хувийн эрүүл мэнддээ анхаарч биеийн тамирын бэлтгэлийг нэн чухалд авч үздэг, тэр утгаараа Онцгой байдлын албаны офицер, ахлагч нарыг биеийн тамирын бэлтгэл, норм нормативыг чанд сахиулж биеийн тамирын сургалтыг 1 дасгал, 1 хичээл, 1 нормативыг алгасахгүйгээр шахаж бэлдүүлдэг. Зураг 1. Оросын холбооны улсын иргэний хамгаалалтын академийн сонсогч нарын биеийн тамирын бэлтгэлийн хичээл



Үүнд: Гүйлт 3км, 5км, 10 км, усан бассейн, Залаанд заагдсан бэлтгэл сургуулилт гэх мэтчилэн. Өвлийн улиралд тал газрын цанын 5, 10км-ийн бэлтгэл, бие бялдрын норм норматив багтдаг. Оросын холбооны улсын онцгой байдлын албанд илүүдэл жинтэй алба хаагч байдаггүй байна. Биеийн тамир-спорт, бие бялдрын бэлтгэлийг зайлшгүй гэж үздэг учир нь: хувь хүний эрүүл мэнд сайжрах, алба хаагчдын эрүүл мэнд, ажлын үзүүлэлт, ажил үүрэг гүйцэтгэх чадвар, тэсвэр тэвчээр сайжрах зэрэг үргэлж сайн зүйлийг дагуулж байдаг байна.

## Дүгнэлт

Монгол Улсын онцгой байдлын албаны офицеруудын хувьд биеийн тамирын бэлтгэл дутмаг. Алба хаагчид биеийн жингийн илүүдэл ихтэй. Тусгай албаны хувьд алба хаагчдын биеийн тамирын бэлтгэлд онцгойлон анхаарах ёстой. Иймд энэ асуудлыг судалж Монгол Улсад мөрдөгддөг бие бялдрын норм норматив стандартыг биеийн тамирын бэлтгэл хичээл болгон Онцгой байдлын албаны офицерын сургалтад суулгаж өгвөл зүйтэй.

Оросын холбооны улсын иргэний хамгаалалтын академийн хувьд биеийн тамирын бэлтгэлийг 7 хоногт 1 удаа 1:30 мин, 7 хоногт 2 удаа бие бялдар, спортоор хичээллэх 2 цагийн хугацааг гаргаж өгдөг. Онцгой байдлын албаны офицеруудын сургалтад мэдээж дүрэм журам, хууль эрх зүйн талаар түлхүү судалдаг боловч мэргэжлийн онцгой байдлаас урьдчилан сэргийлэх, авран хамгаалах хор уршгийг арилгах талын сургалт дадлага дутмаг явагддаг. Онцгой байдлын албаны офицер бүрэлдэхүүний сургалтыг сайжруулах асуудал нь тодорхой үр дүнтэй, тухайн офицерын хувьд өөрийн мэдлэгийг ахиулах, бие бялдрын бэлтгэл хангагдах, өөрийн албан тушаалыг нэг шат дээр албан тушаалд орлон гүйцэтгэх чадварыг эзэмших, гамшиг осол гарсан үед буюу онцгой байдлын нөхцөлд өөрийн хүлээсэн үүрэг даалгаврыг түргэн шуурхай гүйцэтгэх чадвартай сэтгэл зүйн хувьд үргэлж бэлэн байх цаашлаад хариуцсан бие бүрэлдэхүүнийг удирдаж офицерын манлайллыг харуулж чадах түвшинд бэлтгэгдэж төгсөх юм.

Мэдээж сургалт, бэлтгэл хийхийн тулд сургалтын материаллаг бааз, мэргэшсэн сургалтын багш, мэргэжилтнүүд чухлаар тавигдана. Жишээ татахад Оросын холбооны улсын иргэний хамгаалалтын академид онцгой байдлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах улсын нэгдсэн тогтолцоог үе шаттайгаар судлуулдаг. Энэ нь товч утгаараа улсын онцгой байдлын комисс, орон нутгын онцгой байдлын комиссын үйл ажиллагааны уялдаа холбооны нэгдсэн тогтолцоо ба. бага түвшингээс эхэлж судлуулдаг.

Онцгой байдлын нөхцөл байдал хотын нэг дүүрэгт үүссэн үед жишээ нь: Химийн хорт бодис ачсан вагон осолдох ч юмуу онцгой байдлын нөхцөл үүсэхэд тухайн дүүрэгт, осол гарсан газарт хэрхэн ажиллах нөхцөл байдлыг үнэлэх хүч хэрэгсэл, ар тал хангалтыг тооцох зохион байгуулах, нүүлгэн шилжүүлэх, хор уршгийг арилгах цогц үйл ажиллагааны сургалтыг явуулдаг байна. Эндээс сургалтын процесс ердөө танхимд явагдах бөгөөд багшаас цагийн байдал, онцгой байдлын үүссэн газар гамшиг ослын төрөл, тухайн газрын газар-зүйн зураг, бусад цаг уурын өгөгдлүүдийг өгч сургалтад хамрагдаж буй офицеруудыг гурав гурваар нэг баг болгон эхлүүлж, эхний өдрийн сургалтаар багууд өгөгдсөн онцгой байдлын нөхцөлийг судалж танилцах, нөхцөл байдлыг үнэлэх, газрын зураг дээр тэмдэглэгээг хийж эхлэх гэх зэргээр тодорхой өдөр тодорхой цагийн хугацаанд явагдсаар багууд энэ хугацаанд хэд хэдэн удаа авч хэрэгжүүлж буй арга хэмжээ талаар хэд хэдэн дүрд тоглон илтгэл тавьдаг байна. Сургалтын төгсгөлд багуудын боловсруулсан газрын зураг дээрх ажиллагаа, боловсруулсан бичиг баримтууд хавтаслагдаж архивлагддаг. Энэ сургалтаар офицерууд олон олон чадваруудыг эзэмшиж авдаг. Үүнд:

- газрын зураг дээр ажиллах,
- цаг уурын нөхцөлийг тооцох,
- химийн хорт бодисуудын ангилал хор уршгийг мэдэх,

орон нутаг засаг захиргааны байгууллагын уялдаа холбоо харилцан

- хамтран ажиллах,
- хүч хэрэгслийг тооцох,
- тухайн нөхцөлд аврах ажиллагааг хэрхэн зохион байгуулах зэрэг чадваруудад суралцаж эхэлдэг. Энэ сургалт нь үе шат ахих тусам газар нутгийн хэмжээ, гамшиг ослын төрөл томрох нийслэлийн хэмжээний, орон нутгийн хэмжээний, орон нутаг дамнасан гамшиг осол, улсын хэмжээний онцгой байдлын нөхцөлд гэх мэтчилэн үе шаттай явагддаг.

Зураг 2. Оросын Холбооны Улсын, иргэний хамгаалалтын академийн сонсогч нарын штабын бэлтгэл дадлага, сургалт

## Санал

Дээрх туршлагаас харахад, офицерын сургалтыг сайжруулах асуудлын хүрээнд энэ талаар сургалтын багш мэргэжилтнүүдийг олж бэлтгэх, сургалтын материаллаг баазыг үүсгэж хөгжүүлэх, сургалтын төсөв төлөвлөгөөнд суулгаж жилээс жилд сайжруулалт хийснээр жинхэнэ мэргэшсэн офицерууд бэлтгэгдэж онцгой байдлын албаны мэргэжлийн чадавхын түвшин нэмэгдэх болно гэж үзэж байна.

## Ашигласан материал, эх үүсвэрийн жагсаалт

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
2. Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль 2017 он
3. Э.Ганбаатар, Д. Шуурав, Я. Сэржамц, Менежмент. 2017он Улаанбаатар хот
4. [www.nema.gov.mn](http://www.nema.gov.mn) сайт
5. [www.google.mn](http://www.google.mn) сайт
6. Оросын холбооны улсын онцгой байдлын яамны харьяа олон улсын иргэний хамгаалалтын академийн магистрант, ахмад З.Бямбадорж
7. Судалгааны ажлын эмхтгэл 2017-2019 он
8. Менежментийн үндэс зайн сургалтын материал 2007 он
9. Цэргийн сургалт бэлтгэлийн стандарт 2016 он
10. ОБА-ны сургалтын хөтөлбөр , төлөвлөгөө 2018-2020 он
11. Баяржаргал, Б., Батсайхан, Гамшгийн нэр томьёоны тайлбар толь. 2012 он Улаанбаатар хот